



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 20-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-15
1. “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.11.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/	7
2. Улсын Их Хурлын даргыг сонгох тухай	7-15

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
11 дүгээр сарын 20-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 83 гишүүн хүрэлцэн ирж, 65.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 32 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Баатархүү, Б.Батбаатар, П.Батчимэг, Б.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, Э.Болормаа, Д.Ганбат, Д.Рэгдэл, Р.Сэддорж;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Х.Булгантуяа, М.Нарантуяа-Нара, Д.Энхтүвшин;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батлут, Ж.Ганбаатар, Л.Гантөмөр, З.Мэндсайхан, М.Сарнай, Б.Тулга, Ж.Чинбүрэн;

Тасалсан: Т.Аубакир, Э.Бат-Амгалан, Х.Баттулга, Г.Ганбаатар, Б.Жавхлан, Ц.Мөнхтуяа, Д.Пүрэвдаваа, Ө.Шижир;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан -13 минут, О.Амгаланбаатар -09 минут, Ж.Баярмаа -06 минут, Х.Болормаа -08 минут, Т.Доржханд -09 минут, Х.Жангабыл -13 минут, Д.Жаргалсайхан -13 минут, С.Одонтуяа -13 минут, Л.Оюун-Эрдэнэ -13 минут, П.Сайнзориг -13 минут, Д.Цогтбаатар -07 минут, Р.Эрдэнэбүрэн -10 минут.

Өргөн мэдүүлсэн хуулийн төслийг танилцуулах

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа нар байлцав.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 33 гишүүнээс 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Хууль зүйн байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн Гэр бүлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Хууль зүйн байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2025.11.19-ний өдөр өргөн мэдүүлсэн “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороодод тус тус хуваарилсныг танилцуулав./10:34/

Нэг. “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.11.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ Монгол Улсын Засгийн газраас үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг танилцуулав.

Ж.Бат-Эрдэнэ: “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 36
Бүгд: 84
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг гишүүдийн олонхын саналаар яаралтай хэлэлцэхээр шийдвэрлэсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороодод шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Улсын Их Хурлын даргыг сонгох тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн Ажлын албаны дарга С.Далхаасүрэн нар байлцав.

Улсын Их Хуралд олонхын суудал авсан Монгол Ардын намаас Улсын Их Хурлын даргад Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учралыг нэр дэвшүүлснийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Батжаргал танилцуулав.

Улсын Их Хурлын даргыг сонгох тухай асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл 14:00 цаг хүртэл завсарлага авах тухай мэдэгдэж, Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ 14:00 цаг хүртэл завсарлага өгөв./10:45/

Үдээс өмнөх хуралдаан 13 минут үргэлжилж, 10 цаг 45 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 12 минутад эхлэв.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 17 гишүүний боловсруулсан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хүсэлт тавьж, хуулийн төсөл санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Ч.Лодойсамбуу нар хуулийн төслийг Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэд өргөн мэдүүлэв./14:14/

Мөн Улсын Их Хурлын даргыг сонгох тухай асуудлаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дууссан тухай мэдэгдэв./14:15/

Ж.Бат-Эрдэнэ: Монгол Улсын Их Хурлын даргаар Ням-Осорын Учралыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 80
Татгалзсан: 17
Бүгд: 97
82.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын даргаар Ням-Осорын Учралыг сонгохыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ “Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./14:19/

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж Төрийн ордны хамгаалалтан дор Улсын Их Хурлын тамгыг хадаг дээр залж, танхимд орж, хуралдаан даргалагчийн ширээний зүүн хэсэгт байрлуулахад, Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ хүлээн авч, шинээр сонгогдсон Улсын Их Хурлын дарга Н.Учралд гардуулж, суудалдаа морилохыг урив./14:20/

Улсын Их Хурлын дарга Н.Учрал суудалдаа суусны дараа Улсын Их Хурлын нийт гишүүдэд хандан үг хэлж, Төрийн туганд мэхийн ёслов./14:33/

Уг асуудлыг 14 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулганы хуралдааны хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 35 минут үргэлжилж, 126 гишүүнээс 97 гишүүн хүрэлцэн ирж, 77.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 34 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 32 минут.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Ирцийг танилцуулъя. Ирц 65,9 хувьтай болсон байна. Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар 2 асуудлыг хэлэлцэнэ. Нэгд, Улсын Их Хурлын чуулганаар “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

Хоёрт, Улсын Их Хурлын даргыг сонгох асуудлыг шийдвэрлэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлдэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол Зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан байгаа. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаарх танилцуулгыг та бүхэнд танилцуулъя.

1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийг Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн нарын 33 гишүүн 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

2. Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Засгийн газрын газраас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр өргөн мэдүүлснийг Хууль зүйн байнгын хороонд;

3. Гэр бүлийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслийг Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр өргөн мэдүүлснийг Хууль зүйн байнгын хороонд;

4. “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороо болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд тус тус хуваарилсан байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг. “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.11.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/

Улсын Их Хурлын чуулганаар “Тогтоолын төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг яаралтай хэлэлцэх асуудлыг хэлэлцсэн. Тогтоолын төслийг та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд Үндэсний эдийн засгийн аюулгүй аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай мэдүүлэхээр хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ гэж заасны дагуу Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл, тухай хуулийн, тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Гишүүд санал хураалтдаа бэлдье.

Санал хураалт явуулъя. “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 84 гишүүнээс 48 гишүүн оролцож, дэмжиж, 57,1 хувиар санал дэмжигдлээ. Төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Төсвийн байнгын хороо болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүллээ.

Хоёр. Улсын Их Хурлын даргыг сонгох тухай

2 дахь асуудалдаа оръё. Улсын Их Хурлын даргыг сонгох тухай. Улсын Их Хурлын даргыг сонгох асуудлыг хэлэлцье. Монгол Ардын намаас Улсын Их Хурлын даргад нэр дэвшүүлсэн тухай Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Жигжидийн Батжаргал таныг индэрт урьж байна. Танилцуулгаа танилцуулна уу.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 11 дүгээр зүйлийн 11.1, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Ардын намын Удирдах зөвлөл, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн

шийдвэрийн дагуу Монгол Ардын намын дарга, Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учралыг Улсын Их Хурлын даргад нэр дэвшүүлж байна.

Ням-Осорын Учрал 1986 онд төрсөн, эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг. 2003 онд Их засаг лицей сургууль, 2007 онд Их засаг олон улсын их сургууль, 2010 онд Британийн Лимкоквин их сургууль, 2012 онд Монгол Улсын боловсролын их сургууль, 2013 онд Оросын Холбооны Улсын Шинжлэх ухааны академийн Сибирийн салбарын Монгол, Түвд, Будда судлалын институт, 2019 онд Британийн Их сургуулийг тус тус төгссөн. Эрх зүйч, бизнесийн удирдлага, түүхийн ухааны доктор.

Ням-Осорын Учрал 2007-гоос 2008 онд Их засаг олон улсын их сургуулийн ТУЗ-ийн дэд даргаар, 2010-аас 2016 онд Рояль Академи, Рояль олон улсын дээд сургуулийг үүсгэн байгуулагч, ерөнхий захирлаар, 2012-оос 2016 онд Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр, 2012-оос 2014 онд Нийслэлийн Монгол Ардын намын хорооны Улс төрийн хэлтсийн даргаар, 2015 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт Монгол Улсын Шадар сайдын Ажлын алба, Шадар сайдын олон нийттэй харилцах бодлогын зөвлөхөөр, 2016 онд Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн зөвлөхөөр, 2019-өөс 2024 онд Монгол Ардын намын дэргэдэх Нийгмийн ардчилал Монголын залуучуудын холбооны ерөнхийлөгчөөр, 2020-оос 22 онд Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны даргаар тус тус ажилласан.

Ням-Осорын Учрал нь 2016 онд Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон бөгөөд 2022-оос 2024 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдаар, 2024-өөс 25 онд Монгол Улсын сайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар, 2025 оноос Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдаар тус тус томилогдон ажилласан. Тэрээр иргэдийн итгэлийг хүлээж, Улсын Их Хурлын гишүүнээр 3 удаа дараалан сонгогдсон. Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны даргаар ажиллахдаа 30 гаруй хуулийн төслийг санаачлан, ажлын хэсгийг ахлан ажилласан.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс Монгол Ардын намын дарга, Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учралыг парламентад ажилласан байдал, боловсрол, мэдлэг, туршлага зэргийг харгалзан үзэж, Улсын Их Хурлын даргад нэр дэвшүүлж байна. Иймд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэж өгөхийг та бүгдээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Ардчилсан намын бүлгийн дарга Цогтгэрэл.

О.Цогтгэрэл: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Энэ орж ирж байгаа асуудалтай холбогдуулан Ардчилсан намын бүлгээс тодорхой байр суурь илэрхийлсэн. Аль нэг намын дарга парламентын дарга байх нь зарчмын хувьд болоод ёс зүйн хувьд бас зохимжгүй гэдэг байр суурь. Энийг бид хэн нэгэн хүнд зориулж цаг хугацааны хувьд ч ярьсан зүйл биш. Бид өнгөрсөн сард, бүр өнгөрсөн парламентын үед ч гэсэн Ерөнхий сайдын мэтгэлцээний асуудлыг ярьж байхад, олон, олон зүйлүүдийг ярьж байхад бид парламентыг удирдаж байгаа хүний байр суурьтай холбоотой бас яг энэ асуудлыг Ардчилсан намын бүлэг дээр олон удаа яригдаж байсан.

Мөн Амарбаясгалан даргыг Их Хурлын даргыг намын даргаар сонгогдох үед ч гэсэн бид дахиад энэ асуудлыг олон нийтэд ч бас хөндөж ярьж байсан. Аль нэг намын дарга парламентын дарга байх энэ зарчмын хувьд, бүүр олон улсын жишгийн хувьд, бидний даган дуурайх гэж үздэг парламентын ардчилалтай орнуудын хувьд энэ буруу жишиг юм байна. Энийг бид Ардчилсан нам өөрөө парламентын ардчиллынхаа талд байдаг ёстой юм бол энэ зарчмын талд байр сууриа илэрхийлж ажиллах нь зүйтэй гэдэг ийм байр сууриуд өмнө нь гарч байсан зүйл гэдгийг энд тодотгож хэлье.

Манай Монгол Улсын хувьд ч гэсэн сүүлийн 10 жилийн хугацаанд Зандаахүүгийн Энхболд дарга, Миеэгомбын Энхболд дарга гээд дарга нарын үед бас намын дарга нь парламентын дарга байсан. Энэ нь өөрөө сайн биш, зөв биш жишиг байсныг бид бүгдээрээ мэдэж байгаа. Яалт ч үгүй намын дарга гэдэг хүн энэ парламент өөрөө зөвшилцлийн, ойлголцлын, олон улсын болоод ер нь жишгээрээ энэ чинь өөрөө төвч байр суурийг нэхэж байдаг ёстой энэ танхим. Гэтэл энд яалт ч үгүй нэг намын дарга энийг удирдах нь тухайн хүнээсээ үл хамаараад, намын дарга гэдэг хүн нь өөрөө өөр эрх ашигтай, тэр хүнээс үл хамаараад эрх ашигтай. Ийм учраас гэдэг олон, олон шалтгаануудыг хэлж болно. Тэгээд Ардчилсан намын бүлгийн зүгээс энэ асуудлаар бид дахин ярилцах шаардлагатай байна. Ийм учраас бид үдээс хойш 14 цаг хүртэл энэ асуудлаар завсарлага авч, энэ асуудлыг тодорхой байр суурь, байр сууриа нэгтгэх, мөн энэ асуудлаар бэлэн болчихсон байгаа хуулийн төслийнхөө тухай ч ярилцах шаардлагатай байна.

Ийм учраас Улсын Их Хурлын дэд дарга таныг 14 цаг хүртэл энэ асуудлаар завсарлага өгөхийг хүсэж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Аль бүлэг ч, нам, эвслийн бүлгүүд завсарлага авах эрх байгаа. Үдээс хойш 14 цаг хүртэл Ардчилсан намын бүлэгт завсарлага өгье. 14 цаг.

10.45 цаг

*2025 оны 11 дүгээр сарын 20, Пүрэв гараг,
Төрийн ордон “Их хуралдай” танхим
14 цаг 12 минут.*

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдааныг эхлүүлье.

Улсын Их Хурлын даргыг сонгох асуудлыг үргэлжлүүлнэ. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг 2 цаг хүртэл завсарлага авсан. Завсарлага дуусаж байгаатай холбогдуулаад Ардчилсан намын бүлгийн дарга Цогтгэрэл үг хэлнэ.

О.Цогтгэрэл: Гишүүдэд үдээс хойшийн мэнд хүргэе. Завсарлага авсан, Ардчилсан намын бүлэг дээр мэдээлэл солилцож ярилцсан. Олон гишүүн энэ илэрхийлсэн зарчмын байр суурь дээрээ байгааг тодотгоё. Мөн ер нь энэ намын даргын асуудал бол мэдээж намын дотоод асуудал. Улсын Их Хурлыг даргалах хүний асуудал бол Улсын Их Хуралтай, парламенттай холбоотой асуудал гэдгийг заавал онцлон хэлэх ёстой.

Мөн Тэмүүжин гишүүний санаачилсан хуулийн төсөл байгаа. Улсын Их Хурлын дэд даргад гардуулахаар, өргөн барихаар бүрдүүлбэр хангаад, хандчихсан. Улсын Их Хурлын дэд дарга энэ хуулийн төслийг та хүлээж авах цаг өгсөнгүй. хүлээж авсангүй. Улсын Их Хурлын гишүүн хуульд нийцсэн хуулийн төслийг бүрдүүлбэрийг хангаад, өргөн барих болоход танд хүлээж авахгүй байх танд тийм эрх байхгүй. Улсын Их Хурлын дотоод асуудлаарх хуулийг Засгийн газраас санал авдаггүй, санал авдаггүй. Гэтэл та одоо энэ Тэмүүжин гишүүний санаачилсан хуулийн төслийг хүлээж аваад, хэлэлцээд, энийг дэмжих, дэмжихгүй олонхоороо шийдэх дахиад ийм парламентын л зарчим. Энэ заавал энийг дэмжигдэх ёстой гэсэн үг биш.

Харин тэр хууль, дэг ёсоороо Улсын Их Хурлын тухай хуулиараа, Улсын Их Хурлын дэгийн тухай хуулиараа явуулах эсэхийг шийдэх нь Улсын Их Хурлын даргын үүрэг гүйцэтгэж байгаа хүний хуулийн өмнө хүлээсэн үүрэг. Тэгэхээр Тэмүүжин гишүүнийг нэгэнт Улсын Их Хурлын дарга та өргөн барих бололцоо олгохгүй байгаа учраас Тэмүүжин гишүүнийг, энэ хуулийн төслөө та Тэмүүжин гишүүн болоод Тэмүүжин гишүүний хуулийг дэмжиж гарын үсэг зурсан гишүүдийн төлөөллийг яг одоо Улсын Их Хурлын даргад энэ хуулийн төслөө гардуулан өгөөч, өргөн бариач гэж хүсэж байна. Танд хүлээж авахгүй байх эрх байхгүй. Тийм. Тэгээд, баярлалаа, заавал ингэж хүчээр ингэж авах шаардлага байсан уу, үгүй юү? Баярлалаа.

Мөн бид Бүлэг дээрээ ярилцсан. Бүлэг дээрээ ярилцсан. Яг одоо Ардчилсан намын бүлгээс энэ асуудлаар завсарлагыг үргэлжлүүлэх шаардлагагүй гэж бас үзсэн. Одоо байгаа хууль, эрх зүйн хүрээнд асуудлаа яриад, энэ явах нь хуульт ёсонд нийцнэ. Мөн шинээр өргөн барьж байгаа хуулийг хүлээж аваад, хэлэлцүүлээд, дараа дараагийн хэлэлцүүлэгт ороод, энэ асуудлыг зарчмын хувьд шийдээд, олонхоороо шийдээд явах ёстой гэдэг энэ зарчмын шаардлагыг Ардчилсан намын бүлгээс үргэлжлүүлэн тавина гэдгийг хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин болон бусад гишүүдээс өргөн барьж байгаа хуулийн төсөл өргөн мэдүүлсэн тухай албан бичгийг ингээд хүлээж авч байна. Би хэлсэн дүрмийнхээ, хуулийнхаа дагуу бүрдлийг шалгаад, тэгээд цаашдаа мэдээж өргөн барих асуудал нээлттэй, хүлээж авахгүй байх асуудал байхгүй. Засгаас элдэв санал авах хуулийн дагуу тийм зүйл байхгүй. Тийм болохоор энийг цаашдаа хэлэлцээд явах нь, хуулийн дагуу хэлэлцээд явах байх.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 14 цаг хүртэл завсарлага авсан. Ингээд үүгээр завсарлагын хугацаа дууссаныг мэдэгдье. Монгол Ардын намаас Улсын Их Хурлын даргад нэр дэвшүүлсэн тухай Улсын Их Хурлын гишүүн Батжаргал дарга танилцуулгаа хийчихсэн. Одоо санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Гишүүд санал хураалтдаа бэлдье. 97 гишүүнээс 75 гишүүн санал хураалтад бэлэн болсон байна. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Зарим гишүүн бол ороогүй байх шиг байна.

Монгол Улсын Их Хурлын даргаар Ням-Осорын Учралыг дэмжье, сонгохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 97 гишүүнээс 80 гишүүн оролцож, дэмжиж, 82,5 хувиар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын даргаар Ням-Осорын Учралыг сонгохыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Улсын Их Хурлын даргыг сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо. Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байгаа.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай. Монгол Улсын Үндсэн хуулийн 24 дүгээр зүйлийн нэг дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.3 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын даргаар Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учралыг сонгосугай.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Тогтоол сонссонд тооцлоо.

Улсын Их Хурлын тамгыг шинээр томилогдсон Улсын Их Хурлын даргад гардуулах, гардуулан өгөх арга хэмжээг бэлтгэе. Улсын Их Хурлын тамгыг хүндэтгэлтэйгээр залж ирнэ үү. Шинээр сонгогдсон Улсын Их Хурлын дарга Ням-Осорын Учралыг суудалдаа морилохыг урьж байна.

Улсын Их Хурлын дарга Н.Учрал 14 цаг 20 минутаас хуралдааныг даргалав.

Н.Учрал: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Ард түмний элч, төлөөлөгчид өө, Төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурлын даргаар ажиллах итгэл хүлээлгэсэн та бүхэнд гүн талархал илэрхийлье.

Төрийн дээд эрх гагцхүү ард түмнийх учир миний бие ард түмнээс уг сурвалжтай, эх ундаргатай, ардчилсан төрт ёс, парламентын засаглалаа бэхжүүлэхийн төлөө Үндсэн хуулиа сахин баримталж, хичээнгүйлэн ажиллах болно. Ард түмний элч, төлөөлөгчдийн олон ургалч үзэл бодлоо уралдуулах чөлөөт индэр, олон намын сонирхлын, олон бүлгийн өргөн төлөөлөл оролцоотой парламент мэргэжлийн мэтгэлцээний өргөн талбар байлгахын төлөө хичээж ажиллах болно. Улс орны эрх ашгаа эн тэргүүнд, улс төрийн намын асуудлаа хойш нь тавьж, Үндсэн хууль дээдлэн сахих өргөсөн тангаргаа баримталж, хууль тогтоох үндсэн үүргээ биелүүлж ажиллахыг та биднийг элч, төлөөлөгчөө болгосон олон түмэн шаардаж байна. Олон ургалч үзэл бодлоо уралдуулахын зэрэгцээ Монгол Улсын язгуур нийтлэг эрх ашиг, гагцхүү шударга ёсонд суурилсан эв эеийг хичээн улс орныхоо илүү сайхан ирээдүйн төлөө хамтдаа хичээж ажиллацгаая.

Хууль тогтоох дээд байгууллагаас хулгайн сэжигтнүүд биш, хууль төрж байх ёстой. Улсын Их Хурлын нэр хүнд гишүүн гэмт хэрэгт шалгуулаад байгаагаас болж унаагүй. Улсын Их Хурлын нэр хүнд Улсын Их Хурлын гишүүн шалгуулахгүй байх давуу дархан эрхээс болж унаж байгаа нь үнэн. Ард түмний төлөөлөгч ард түмэнтэйгээ адил хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх цагт парламентын нэр хүнд өсөх болно.

1 дүгээрт, парламентыг Үндсэн хуулиа дээдлэн сахих, хууль дээдлэх, шударга ёс, ёс зүй, тэгш эрхийн зарчмыг Улсын Их Хурал өөрөөсөө эхлүүлэн үлгэрлэх хэрэгтэй. 2 дугаарт, судалгаа, их өгөгдөл, шинжлэх ухаанд суурилсан цаг үе, олон улсын чиг хандлага, хэрэгцээ шаардлагадаа нийцсэн хууль тогтоомжийг хэлэлцэн баталж байх үүрэгтэй. 3 дугаарт, олон ургалч үзэл бодлын мэтгэлцээний талбар байх ёстой. 4 дүгээрт, олон нийтэд илүү нээлттэй, ойрхон, ил тод, шилэн парламент болж төлөвших учиртай. Эдгээр 4 зорилтыг Улсын Их Хурлын даргын хувьд баримталж ажиллана. Энэ бүхний үр дүнд ард түмэн төлөөллөөрөө дамжуулж, төрийн эрхийг барих парламентын засаглал бэхжих болно.

Миний бие төрийн эрх барьж байгаа Монгол Ардын намын дарга боловч Үндсэн хуулиа ягштал сахин баримталж, Их Хурлын гишүүдийн үзэл бодол, байр сууриа илэрхийлэх, хууль санаачлах бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь аливаа ялгаварлалгүйгээр, эрх тэгш, хүндэтгэлтэй хандах болно. Улсын Их Хурлын дарга бол Улсын Их Хурлын гишүүдээс илүү эрх эдлэх биш, илүү үүрэг хүлээсэн ажил алба. Улсын Их Хурлын гишүүдийн санал бодол, байр суурь, олонхын саналаар хэлэлцэн гаргах шийдвэрт нөлөөлдөг давуу эрхтэй албан тушаалтан биш. Улсын Их Хурлын дарга бол Улсын Их Хурлын бусад гишүүдтэйгээ адил ард түмнээс сонгогддог, Их Хурлын хуралдааныг зохион байгуулах чиг үүрэгтэй гэдэг итгэл үнэмшлээсээ би ухрахгүй. Үндсэн хуулиа дээдлэн сахих, эрх, үүргийн нэгдлийг хангах, тэгш эрх, шударга ёс энэ танхимаас эхэлж байх ёстой. Үндсэн хууль, хууль дээдэх ёсны өмнө улс төрийн нам, нас, хүйсийн ялгаа зааг ямар ч давхар стандарт байх учиргүй.

Та бид ард түмний 126 дарга биш. Та бид ард түмний 126 элч, төлөөлөгч. Илүү тусгай эрх дархтай, ард түмэнд зааж зааварладаг дарга нар бид биш. Улс төрийн намын бус, улс орны, ард иргэдийн эрх ашгийг эн тэргүүнд эрэмбэлэн дээдэлж, нийгмийн хүсэл хүлээлт, хэрэгцээ шаардлага, дэлхийн чиг хандлага, цаг үедээ нийцсэн хууль тогтоомжуудыг судалгаа шинжилгээ, иргэд, иргэний нийгэм, эрдэмтэн судлаачдын өргөн идэвхтэй оролцоонд тулгуурлаж, хэлэлцэн баталж байх нь та бидний онцгой үүрэг юм. Улсын Их Хурлаас батлан гаргасан хууль тогтоомжууд хийдэл, давхардалтай, өөр хоорондоо зөрчилдсөн, цаг үеэсээ хоцорсон, нийгмийн харилцаа зохицуулах чадваргүй, хүний эрх, эдийн засгийн эрх чөлөөг хааж боосон, зөрчилдөж хязгаарласан хуулиудыг иж бүрнээр нь өөрчилж, хууль тогтоох, Засгийн газарт хяналт тавих үндсэн үүргээ биелүүлэхэд онцгойлон анхаарч ажиллах болно.

Засгийн газрын бодлого, үйл ажиллагаанд намчирхалгүйгээр хяналт тавьж, зөвд зөөлөн, бурууд хатуу байж, шийдлээ хүлээсэн асуудлын гарц шийдлийг олж, хүний эрхийг зөрчсөн, улс орны хөгжилд саад болсон хуулийн гох дэгээг тайлж ажиллах болно. Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтэд парламентын хяналт тавьж, гүйцэтгэлийн хариуцлага нэхэж шаардаж ажиллана. Монгол Улсын 5 жилийн хөгжлийн үндсэн чиглэл, тэтгэврийн зээлийн хугацаа 24 сар байгааг 36 сар болгох зэрэг нийгмийн хэрэгцээ шаардлагыг шуурхай мэдрэн, санал санаачилгатай ажиллахыг та биднээс цаг үе, бодит нөхцөл байдал шаардаж байна.

Улсын Их Хурлын хэлэлцэн баталж байгаа тогтоол, шийдвэр бүхэн Монгол Улсын эдийн засгийн тусгаар тогтнол, Монгол хүний эдийн засгийн эрх чөлөөг дархлан бататгах, ардчилсан нийгэм, чөлөөт зах зээлийн харилцааг төгөлдөршүүлэхэд чиглэгдэх учиртай. Улсын Их Хурал энэ өдрүүдэд Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийг хэмжиж болохуйц, хүрч болохуйц, цаг

хугацаатай, бодит байх шаардлагад үндэслэн, шинжлэх ухаанд тулгуурлан боловсруулсныг хэлэлцэж байна. Монгол Улсын эдийн засгийн тусгаар тогтнолыг бататгах, Монгол хүний эдийн засгийн эрх чөлөөг дархлахын төлөө гарц шийдэл, санал бодлоо уралдуулж ажиллахыг бодит нөхцөл байдал сануулж байна. Улсын Их Хурал төрийн зуршлаас хувийн хэвшлийг чөлөөлж, төрийн оролцоог хумьж, шударга өрсөлдөөнийг хөхиүлэн дэмжих бодлогыг тууштай хэрэгжүүлэхэд анхаарах ёстойг Улсын Их Хурлаас хэлэлцэн баталсан Төсвийн хүрээний мэдэгдэлд төсвийн орлого, дотоодын нийт бүтээгдэхүүний харьцааг 2026 онд 30,9 хувь, 2027 онд 29,3 хувь, 2028 онд 28,2 хувь болгон бууруулах зорилт тусгагдсан нь төрийн оролцоо багасаж, зах зээлийн боломж улам өргөжихийн эхлэл болсон.

Төсвийн нийт зардал, дотоодын нийт бүтээгдэхүүний харьцааг 2028 он гэхэд 28,6 хувь болгон бууруулснаар төсвийн зардлын үр ашгийг нэмэгдүүлж, эрэлтийн гаралтай инфляцыг хязгаарлаж, мөнгөний бодлоготой уялдан дунд хугацаанд инфляцыг бууруулах нөхцөл боломж бий болно. Энэхүү орон зайд Засгийн газраас олон нийтийн хэлэлцүүлэгт байгаа Татварын багц хууль, Хувийн өмч хөрөнгийг хурааж, нийгэмчлэх, эрх зүйн байдлыг нь дордуулсан шийдвэр гаргах гаргахыг хориглосон Эдийн засгийн эрх чөлөөний тухай анхдагч хууль, Хөрөнгө оруулалтын хуулийн нэмэлт, өөрчлөлт, Зөвшөөрөл, мэдэгдлийн хуулийг Улсын Их Хурал намрын чуулганаараа батлах болно.

Эдийн засгийн эрх чөлөөтэй зөрчилдөж болзошгүй 228, шууд зөрчилдөж байгаа 110 хууль, нийт 378 хуулийг хиймэл оюунд тулгуурлан илрүүлсний гох дэгээг энэ хуулиар тайлж байгаа шигээ Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 430 гаруй хуулиас эдийн засгийн эрх, эрх чөлөө, хүний эрх, эрх чөлөө, улс төрийн эрх, эрх чөлөөг зөрчсөн хуулиуд дээр хиймэл оюуны тусламжтайгаар дүн шинжилгээ хийж, нэмэлт, өөрчлөлт оруулах болно. Хуулиас давсан журамгүй журам, дүрэмгүй дүрмийг хориглоно.

Гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалж, харилцан ашигтай хамтран ажиллах хууль, эрх зүйн орчноо өөрчлөх нь хөгжлийн гарц мөн. Хөрөнгө оруулалтыг дагаад дэвшилтэт шинэ технологи, шинэ соёл, хийх ажил, олгох цалин, төлөх татвар нэмэгддэг. Юм бүхнийг хийх гэдэг биш, юу хийхгүйгээ мэддэг цомхон төр болох эрх зүйн эрүүл саруул орчныг энэ танхимд бүрдүүлэх хэрэгтэй. Бизнес эрхлэгчдээ дэмжих зорилгоор татвар, нийгмийн даатгалын тогтолцоонд бодит шинэчлэл хийх шаардлага тавигдаж байна. Татварын шинэчлэлийн үр дүн нь төрийн зуршлыг халж, хувийн хэвшилд орон зай, хөгжих зам нээхэд оршино. Төсвийн тэлэлтийг хязгаарлах нь цалин, орлогыг үнэгүйдүүлэгч инфляцын дарамтыг буулгах болно. Аж ахуйн нэгжүүд Монгол хүнд ажил олгож, цалин өгч, илүү урамшуулж, үнэлснийхээ төлөө илүү их шимтгэл төлөөд байвал Халамжаас-хөдөлмөрт бодлого бодит ажил хэрэг болохгүй.

2021 онд Улсын Их Хурлын гишүүний хувиар санаачилж байсан Хувийн нэмэлт тэтгэврийн сангийн хуулийг баталж, олон давхаргад тогтолцоонд шилжүүлж, ахмад настан олон төрлийн сангаас тэтгэвэр авах тогтолцоог бүрдүүлэх нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан 2030 онд тэтгэврийн хэмжээг ажиллагчдын дундаж цалингийн 35 хувьд хүргэх зорилтыг биелүүлэх хөшүүрэг болох болно.

Данхар том төрөөс ухаалаг цомхон төрд шилжихийн тулд чиг үүргийн хийдэл давхардлыг арилгах, төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодод шилжүүлэх,

гэрээгээр гүйцэтгүүлэх, төрийн албанд үр дүн, гүйцэтгэлд үндэслэсэн нэмэгдлийн систем нэвтрүүлж, хийснийхээ хэрээр авдаг болох, үндсэн ажлаас гадна нэмэлт орлого олдог эрх чөлөөтэй байх нь цомхон төр болох хууль, эрх зүйн эрс өөрчлөлт, шинэчлэлт нэн шаардлагатай байна. Улсын Их Хурлаар хэлэлцэх эсэх нь дэмжигдсэн Төрийн өмчийн компанийн бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах тухай хуулийг Улсын Их Хурал яаралтай баталж, Улсын Их Хурал хяналт тавьж, төрийн хувийн хэвшилтэй өрсөлдөх компани цаашид байгуулахыг хуульчлан хориглох, төрийн өмчит компаниудыг хувьчлах, татан буулгах, нэгтгэх, олон улсын аудит оруулах, нээлттэй компани болгох ажлыг шуурхайлахад ташуур өгөх ёстой.

Эрүүл, тогтвортой эдийн засгийн тулгуур нь үр ашигтай, өрсөлдөөнтэй, хүртээмжтэй санхүүгийн сектор юм. Гадаадын банкны салбар нэгжийг дотоодын санхүүгийн зах зээлд нэвтрэх боломжийг нээж, хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээрх ажлыг идэвхжүүлнэ. Ингэснээр өрсөлдөөн нэмэгдэж, санхүүжилтийн өртөг, зээлийн хүү буурч, санхүүгийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, тогтвортой ажлын байрыг нэмэгдүүлэх нөхцөл бүрдэнэ. Цаашид банкны салбарт хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, хууль, эрх зүйн орчин, зохицуулалтыг боловсронгуй болгоход анхаарч ажиллана. Банкны реформыг эрчимжүүлж, эх үүсвэрийн зардлыг бууруулах, инфляцын түвшин тогтворжих орчныг бүрдүүлэх замаар санхүүжилтийн өртөг, зээлийн хүүг аажмаар бууруулах боломжийг тэлнэ.

Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг эрчимжүүлэхийн тулд мэргэжлийн хөрөнгө оруулагчдын суурийг тэлж, урт хугацааны хариуцлагатай хөрөнгө оруулалт татах эрх зүйн шинэчлэлийг эхлүүлнэ. Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын үр ашгийг нэмэгдүүлж, менежментийг олон улсын жишигт нийцүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Өнөөдөр дундаж тэтгэврийн хэмжээ 867 мянган төгрөг, бүрэн тэтгэврийн доод хэмжээ 689 мянган төгрөг байгаа бөгөөд дундаж тэтгэврийн зээлийн хэмжээ 6,4 сая, хүү 16,4 хувь байна. Санхүүгийн хүртээмжийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, ахмадын тэтгэвэр барьцаалсан зээлийн хугацааг 24 сар байгааг 36 хүртэлх сар болгож ахмадууддаа ээлтэй болгох асуудлыг ойрын хугацаанд шийдвэрлэх болно. Даатгалын зах зээлийг олон улсын сайн туршлагад нийцүүлж, шинэ шатад гаргаж, салбарын эрх зүйн орчныг иж бүрэн шинэчилж, тогтвортой өсөлтийг хангах эрх зүйн шинэтгэлээ эрчимжүүлнэ. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг Мэргэжлийн хөрөнгө оруулалтын сангийн зарчмаар удирдаж, хараат бус, ил тод, хариуцлагатай засаглал бүхий тогтолцоог хуулиар бүрдүүлнэ. Орлогод суурилсан зорилтот бүлгийг дэмжих Орон сууцжуулалтын бодлогын хүрээнд хөнгөлөлттэй ипотекийн зээлийг зорилтот бүлэгт чиглүүлж, бодит хэрэгцээтэй өрхүүдийн хүртээмжийг нэмэгдүүлж, хэрэгжилтийн хийдлийг арилгана.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улс орон, ард түмнийхээ язгуур эрх ашгийг эрхэмлэн дээдэлж, Үндсэн хуулиа сахин баримталж, эрх зүйн эрүүл орчныг бүтээхийн төлөө олон ургалч үзэл бодлоо уралдуулцгаая. Монгол Улсынхаа Монгол Улсын эдийн засгийн тусгаар тогтнол, Монгол хүний эдийн засгийн эрх чөлөөг дархлах эрх зүйн иж бүрэн шинэчлэлийн төлөө хамтдаа ажиллацгаая.

“Мөнх тэнгэрийн дор Монгол Улс мандан бадрах болтугай.” Улсын Их Хурлын эрхэм гишүүддээ баярлалаа.

14.33 цаг

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА